

“БОРНУУР ХК” ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХОЙШЛОГДСОН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ПРОТОКОЛ

2023 оны 11 сарын 08

Борнуур сумын Соёлын төв

Хурал эхэлсэн цаг- 11:20 минут

Хурал дууссан цаг- 12:15 минут

Хурлыг нээж хурлын дарга Ш.Номин-эрдэнэ нээв.

Хурлын дарга Ш.Номин-эрдэнэ: Хуралд хувьцаа эзэмшигч нар хүрэлцэн ирсэн байна. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс авсан бүртгэлийн судалгаанд нийт 197,969 ширхэг хувьцааны 41,580 ширхэг буюу 21%-ийг бүрдүүлсэн учраас Компанийн тухай хуулийн 69 дүгээр 69.4 дэх зүйлийн дагуу хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хийхэд хүчин төгөлдөр гэж үзэж хурлыг эхлүүлэв. Итгэмжлэлээр Д.Дагиймаа-30,000ш, Д.Эрдэнэчимэг-11,580ш хувьцааг төлөөлөн Ц.Нарангэрэл нийт хувьцааны 21% хувь болон оролцож байна.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан
2. 2023 онд үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах
3. ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох
4. Ноогдол ашиг тараахгүй байх тухай ТУЗ-ийн шийдвэр

Хэлэлцэх асуудал бүрийг танилцуулах-5 минут

Асуулт хариулт-3 минут

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Э.Батдорж: Компанийн үйл ажиллагаа явуулах доголдол үүссэн хэдий ч хууль шүүхийн байгууллага болон бусад холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх боломж бололцоог бүрэн хангаж ажиллахыг зорьсон. Мөн цаашдын хөрөнгө оруулалт гэрээ хэлэлцийг батлах зэрэг олон ажлыг гүйцэтгэлээ.

Гүйцэтгэх захирал Т.Хүрэлбаатар: За сайн байна та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Компаний гүйцэтгэх удирдлага томилогдсоноос хойш олон үйл ажиллагааг төлөвлөж хийсэн. Мөн газрын маргааны асуудлаас шалтгаалж санхүүгийн асуудлууд гарч ирснийг зээл хэлбэрээр төлж барагдуулсан. Өнөөдрийн байдлаар үйл ажиллагаа явуулаагүй

учраас санхүүгийн маш хүндрэлтэй асуудалтай тулгарч байгаа. Тэгсэн хэдий ч энэ бүхнийг дотоод нөөц бололцоогоороо зохицуулж байгаа.

Хурлын дарга Ш.Номин-эрдэнэ: За эхний хэлэлцэх асуудлаа ярилцая.

Үүний дагуу Гүйцэтгэх захирал Т.Хүрэлбаатар санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг тавив.

Гүйцэтгэх захирал Т.Хүрэлбаатар: “Борнуур” ХК-ийн үйл ажиллагааг анх 2018 оноос хойш тухайн үеийн гүйцэтгэх удирдлагаас компанийн эд хөрөнгө үйл ажиллагааг хүлээн авсан хэдий ч хөрөнгө дутсан асуудлаар холбогдох хууль шүүх шатны байгууллагаар дамжуулан араас нь хөөцөлдөх арга хэмжээг авч Төв аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандаж шүүхдэлцэж байгаа. Дэлгэрэнгүй тайланг хурлын дараа та бүхэнд үзүүлнэ.

Ц.Нарангэрэл: Холбогдох бүхий л арга хэмжээг авч байгаа гэж найдаж байна.

Хурлын дарга Ш.Номин-эрдэнэ: За тэгвэл хурлын хэлэлцэх асуудлын дагуу 2023 онд үйл ажиллагааны төлөвлөлөөг хэлэлцэх ажилдаа орьё.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Э.Батдорж: Компани зүгээс 2023 онд нэлээд хэдэн ажил төлөвлөсөн байгаа. Тэр дундаа санхүүгийн үйл ажиллагаа зогсонги байгаа учраас цаашид арилжаа сэргээх тал дээр бүрэн анхаарах. Ашиглахгүй байгаа барилга, байгууламжыг эргэлтэнд оруулах хэлцэл хийх зэрэг олон ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Хурлын дарга Ш.Номин-эрдэнэ: За тэгвэл хурлын хэлэлцэх асуудлын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох ажилдаа орьё.

Борнуур хувьцаат компаниас:

1. Т.Хүрэлбаатар
2. Б.Отгонжамба
3. Х.Олонбаяр
4. А.Батжаргал
5. Ц.Нарангэрэл
6. Э.Батдорж
7. Б.Наранцогт
8. Г.Угтахбаяр

9. Б.Балдансамбуу

Т.Хүрэлбаатар-1998 онд Өвөрхангай аймагт төрсөн. 2020 онд ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийг төгссөн.”Монголын төмөр зам” ТӨХК-д тээврийн инженер ажилладаг. “Борнуур” ХК-ийн Гүйцэтгэх захирал

Б.Отгонжамба-1985 онд Төв аймгийн Борнуур суманд төрсөн.2003 онд Төв аймгийн Борнуур сумын ЕБС төгссөн. Өгөөмөр хайрхан ХХК-ийн захирал

Х.Олонбаяр-1974 онд Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум. 1990 онд Төв аймгийн Борнуур сумын ЕБС төгссөн. Хувиараа бизнес эрхэлдэг.

А.Батжаргал-1983 онд Төв аймгийн Борнуур суманд төрсөн.2001 онд Төв аймгийн Борнуур сумын ЕБС төгссөн. Төв аймгийн Борнуур сумын ЕБС-д Монгол хэл, уран зохиолын багшаар ажилладаг.

Ц.Нарангэрэл-1986 онд Төв аймгийн Борнуур суманд төрсөн. 2004 онд Борнуур 10 жилийг төгссөн. Хувиараа бизнес эрхэлдэг.

Э.Батдорж-1987 онд Төв аймгийн Борнуур суманд төрсөн. 2008 онд МУИС төгссөн. ШУА Газарзүй гео экологийн хүрээлэнд ажилладаг. ”Борнуур” ХК-ийн ТУЗ-ийн дарга

Б.Наранцогт-1971 онд Сэлэнгэ аймгийн Хонгор сум.1989 онд Төв аймгийн Борнуур сумын ЕБС төгссөн. Эдийн засагч мэргэжилтэй. ХАМО ХХК-ийн Ерөнхий захирал

Г.Угтахбаяр-1986 онд Төв аймгийн Борнуур суманд төрсөн. 2002 онд Борнуур 8 жилийг төгссөн. Хувиараа бизнес эрхэлдэг.

Б.Балдансамбуу-1986 онд Улаанбаатар хот 3-р төрөхөд төрсөн. 2004 онд Борнуур 10 жилийг төгссөн. Төв аймгийн Борнуур сумын ЕБС-д Математикийн багшаар ажилладаг.

Тооллогын комисс санал хураалт явуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн санал:

1. Т.Хүрэлбаатар -41,580
2. Б.Отгонжамба -41,580
3. Х.Олонбаяр -41,580
4. А.Батжаргал -41,580
5. Ц.Нарангэрэл -41,580
6. Э.Батдорж -41,580
7. Б.Наранцогт -41,580
8. Г.Угтахбаяр -41,580
9. Б.Балдансамбуу -41,580

Энэ 9 хүн төлөөлөн удирдах зөвлөлд сонгогдож байна. Дээр 9 хүний төлөөлөн удирдах зөвлөлд сонгогдсоныг батлах тогтоол гаргана.

- Тогтоолтой танилцаж, хурал хаагдана.
- Компани үйл ажиллагааны ноогдол ашиг хуваах тухай /Зөвшөөрсөн, Татгалзсанаар/ тогтоол гаргана.
- Тогтоолын төсөл /Тооллогын комиссын шийдвэрээр/
- 9 хүнийг төлөөлөн удирдах зөвлөлд сонгогдсоныг батлах
- Компани үйл ажиллагааг тогтвортой авч явах үүрэг олгох

Хурлын дарга Ш.Номин-эрдэнэ: За тэгвэл хурлын хэлэлцэх асуудлын дагуу ноогдол ашиг тараахгүй байх тухай ТУЗ-ийн шийдвэр хэлэлцэх ажилдаа орё.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Э.Батдорж: “Борнуур” ХК-ийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд үндэслэн ноогдол ашиг хувиарлахгүй байх тухай 2023 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн 01 тоот тогтоол гаргасан.

Ц.Нарангэрэл: Тогтоолыг дэмжиж байна.

Ийнхүү хурлыг хаасныг мэдэгдэе.

ХУРЛЫН ДАРГА



Ш.НОМИН-ЭРДЭНЭ